



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/03

Хужирт сум

Коронавируст халдвар (COVID-19)-ын үед
ор нэмэлтээр дэлгэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.5, 10.4.4, 18 дугаар зүйлийн 18.4, 32 дугаар зүйлийн 32.1.9 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “ Коронавируст халдвар (COVID-19)-ын оношлогоо эмчилгээний түр заавар шинэчлэн батлах туай” А/549 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд коронавируст халдвар (COVID-19)-ын тоо эрс нэмэгдэж байгаа тул Ерөнхий боловсролын сургуулийн Хүүхдийн 2 дугаар дотуур байрыг тусгаарлан ажиглах байр болгон 60 ор, Хүүхдийн 1 дүгээр Цэцэрлэгийг тусгаарлах эмнэлэг болгон 25 ор тус тус дэлгэсүгэй.

2. Тусгаарлах эмнэлэг, ажиглах байранд дайчлан ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг томилох, шаардлагатай эм, эмнэлэгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хоол хүнсний бэлэн байдлыг хангаж нөөцийг бүрдүүлэхийг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Э.Оюунпүрэв)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ